



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/64

Халбан

**Хагас жилийн мал тооллого зохион
байгуулах ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 "в" дахь заалт, Аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/254 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хагас жилийн мал тооллогыг товлосон хугацаанд сумын хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Хагас жилийн мал тооллогыг товлосон хугацаанд багийн хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Тооллогын ажлын бэлтгэлийг сайтар хангуулж, мөрдөгдөж буй заавар журмын дагуу чанартай зохион байгуулж, түүвэрт сонгогдсон өрхийн малыг тооллогод бүрэн хамруулах, тооллогын мэдээллийн үнэн бодит байдлыг хангах, төрийн албан хаагчдын хариуцлагыг өндөржүүлэх гарч буй зөрчил дутагдлыг газар дээр нь залруулж, холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Отгонбаяр)-т даалгасугай.

4. Хагас жилийн мал тооллогын төсвийг Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн данснаас зарцуулсугай.


5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Бямбажав)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Н.АНХБАЯР

Сумын Засаг даргын 2024 оны 05
дугаар сарын 22-ны өдрийн А/64 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



Хагас жилийн мал тооллогын ажлыг суманд зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Д.Отгонбаяр (Засаг даргын Орлогч)

Гишүүдэд: Б.Даваа (Дэлгэрхаан багийн Засаг дарга)

Х.Билэгсайхан (Зуунмод багийн Засаг дарга)

Ч.Цог-Эрдэнэ (Ренчинжугнай багийн Засаг дарга)

Д.Баясгалан (Уранхайрхан багийн Засаг дарга)

Д.Мөнх-Эрдэнэ (Халбан багийн Засаг дарга)

Н.Эрхэмбаяр (Жаргалант багийн Засаг дарга)

Д.Дамжинрагчаа (Бүрхээр багийн Засаг дарга)

Н.Ганжуур (Татварын Улсын байцаагч)

Б.Дашренчин (Байгаль хамгаалагч)

Л.Дамдинсүрэн (Байгаль хамгаалагч)

Г.Оюунчимэг (Санхүү албаны дарга)

М.Ренчиндорж (Нярав)

Нарийн бичгийн дарга: Ч.Буян-Өлзий (Төрийн сан, статистик хариуцсан мэргэжилтэн)

-----oOo-----

Сумын Засаг даргын 2024 оны 05
дугаар сарын 22-ны өдрийн А/64 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

Хагас жилийн мал тооллогын багт ажиллах ажлын хэсгийг дараах
бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Дэлгэрхаан багт

Б.Даваа (Дэлгэрхаан багийн Засаг дарга)
М.Ренчиндорж (Засаг даргын Тамгын газрын Нярав)

Зуунмод багт

Х.Билэгсайхан (Зуунмод багийн Засаг дарга)
Ч.Бямбасүрэн (Мал зүйч)

Ренчинжугнай багт

Ч.Цог-Эрдэнэ (Ренчинжугнай багийн Засаг дарга)
Н.Ганжуур (Татварын Улсын байцаагч)

Уранхайрхан багт

Д.Баясгалан (Уранхайрхан багийн Засаг дарга)
Б.Дашренчин (Байгаль хамгаалагч)

Халбан багт

Д.Мөнх-Эрдэнэ (Халбан багийн Засаг дарга)
Г.Оюунчимэг (Санхүү албаны дарга)

Жаргалант багт

Н.Эрхэмбаяр (Жаргалант багийн Засаг дарга)
Д.Отгонбаяр (Засаг даргын Орлогч)

Бүрхээр багт

Д.Дамжинрагчаа (Бүрхээр багийн Засаг дарга)
Ч.Буян-Өлзий (Төрийн сан, статистик хариуцсан мэргэжилтэн)

-----oO-----